



Төвийг хүмүүжүүлэх охидын сургуулийн дүрэм, сургалтын бодит байдлын тухай шинжилгээ

NAZHAORIGETU

Монгол Улсын Боловсролын Их сургууль, Улаанхад дээд
сургууль

Галиндэвийн Өлзийсайхан

Монгол Улсын Боловсролын Их сургууль

<https://journal.mnier.mn>

Санал болгож буй эшлэл:

NA ZHAORIGETU., Өлзийсайхан, Г. (2024). Төвийг хүмүүжүүлэх охидын сургуулийн дүрэм,
сургалтын бодит байдлын тухай шинжилгээ. *Боловсролын Судалгааны Монголын Сэтгүүл*,
29(2). <https://doi.org/10.56380/mjer.v29.2.3>

Analysis of the Rules and Educational of Yuzheng Girls' School

NAZHAORIGETU

Mongolian National University of Education, Chifeng University
Galindev Ulziisaikhan

Mongolian National University of Education

To cite this article:

NA ZHAORIGETU., Ulziisaikhan, G. (2024). Analysis of the rules and educational situation of
Yuzheng Girl's school. *Mongolian Journal of Educational Research*, 29(2).

<https://doi.org/10.56380/mjer.v29.2.3>

The International Journal of Studies in Education and Science (IJSES) is a peer-reviewed scholarly online journal. This article may be used for research, teaching, and private study purposes. Authors alone are responsible for the contents of their articles. The journal owns the copyright of the articles. The publisher shall not be liable for any loss, actions, claims, proceedings, demand, or costs or damages whatsoever or howsoever caused arising directly or indirectly in connection with or arising out of the use of the research material. All authors are requested to disclose any actual or potential conflict of interest including any financial, personal or other relationships with other people or organizations regarding the submitted work.



This is an open access article under the Creative Commons Attribution-NonCommercial-ShareAlike 4.0 International License.



Төвийг хүмүүжүүлэх охидын сургуулийн дүрэм, сургалтын бодит байдлын тухай шинжилгээ

NA ZHAORIGETU, Галиндэвийн Өлзийсайхан

Өгүүллийн мэдээлэл

Өгүүллийн түүх:

Хүлээн авсан: 2024.01.14
Засаж сайжруулсан: 2024.09.05
Хэвлэхийг зөвшөөрсөн: 2024.10.23

Түлхүүр үг:

Төвийг хүмүүжүүлэх охидын сургууль, Язгууртны охидын сургууль, сургуулийн дүрэм, сургалтын бодит байдал, хичээлээс гадуурх үйл ажиллагаа

ХУРААНГУЙ

Гүнсэnnоровын байгуулсан ‘Төвийг хүмүүжүүлэх охидын сургууль’ нь Монгол үндэстний боловсролын түүхэнд дэх охидын анхны сургууль юм. Энэхүү өгүүлэлд ‘Төвийг хүмүүжүүлэх охидын сургууль’ болон японы Язгууртны охидын сургуулийн дүрэмд харьцуулалт хийх, Төвийг хүмүүжүүлэх охидын сургуулийн сургалтын бичиг баримт, өмнөх судалгаа, нийтлэлүүд шинжилгээ хийж тус сургуулийн сургалтын бодит байдалд дүгнэлт хийв. Сургуулийг байгуулахад япон эмэгтэй багшийг урин ажиллуулж ‘Төвийг хүмүүжүүлэх охидын сургууль’ -ийн дүрэмийг боловруулжээ. Сургалтын агуулгыг энгийнээс нарийн, гүехэнээс гүн рүү гэсн үе шат бүхий боловсролын зарчмыг агуулсан байна. Хэдийгээр Гүнсэnnоровын боловсролын анхны зорилго нь япон маягийн боловсролыг бүрэн суулгах бус, харин Монгол угсаатны боловсролыг сэргээх зорилготой байсан ч япон эмэгтэй багшийн боловсролын үйл ажиллагааны цаана японы боловсролын нөлөө тусчээ.

Энэхүү өгүүлэл нь *Creative Commons Attribution-NonCommercial-ShareAlike 4.0* олон улсын лицензээр хамгаалагдсан болно



Холбоо барих зохиогч:

NA ZHAORIGETU
Монгол Улсын Боловсролын Их Сургууль, Улаанхад дээд сургууль
Мэйл хаяг: zhaori1223@163.com

Analysis of the Rules and Educational of Yuzheng Girl’s School

NA ZHAORIGETU, Ulziisaikhan, G

Article information

Article history:

Received: Jan 14, 2024
Revised: Sep 05, 2024
Accepted: Oct 23, 2024

Keywords:

Yuzheng Girls' school, Aristocratic Girls' school, School Rules, The actual situation of education, Extracurricular Activities

ABSTRACT

Gunsunorov’s 'Yuzheng Girls' School' is the first girls' school in the history of Mongolian education. By comparing the rules of the Yuzheng Girls' School with those of Japanese Aristocratic Girls' Schools, and analyzing documents, previous research, and sources such as the Yuzheng Girls' School's teaching materials, this article examines the reality of education at the Yuzheng Girls' School. When the school was established, a Japanese teacher was invited to work there. The curriculum followed an educational principle of progressing from shallow to deep, step by step. Although Gunsunorov’s primary goal was not to completely adopt Japanese-style education but to revive Mongolian ethnic education, the presence of Japanese female teachers in the school reflected a tendency towards educational influence and expansion.

This is an open access article under the *Creative Commons Attribution-NonCommercial-ShareAlike 4.0 International License*.



Corresponding author:

NA ZHAORIGETU
Mongolian National University of Education, Chifeng University
Email: zhaori1223@163.com

УДИРТГАЛ

Олон мянган жилийн турш феодалын тогтолцоо оршин тогтнож байсан Хятад улсад эмэгтэй хүнийг ялгаварлан гадуурхаж, дарладаг нь феодалын ёс зүй, ёс суртахууны гүн үндэстэй юм. “Эмэгтэй хүний авьяасгүй нь буян”, “Бичиг үсэгтэй эмэгтэйчүүд садар самуун” (Сун Чанлян, 2017, х. 157) гэсэн ойлголтууд зонхилж байсан юм. Манж Чин улс 1894 оны Хятад-Японы нэгдүгээр дайнд ялагдал хүлээж, “Хүчтэй дайснаа багш болгох” тугийг өндөрт өргөж, Япон маягийн шинэчлэлийг ахиулж, (Жиан Ихуа нар, 1998, х. 104) улс орноо баяжуулж, армия хүчирхэгжүүлэхийг эрмэлзжээ. Манж Чин улсын засгийн газар “Шинэ засаг”-ийн тугийг өндөрт өргөж, “сургууль байгуулж, барууны соёлыг сурталчлах” томоохон ажил эхлүүлсэн ч охидын сургууль байгуулахыг эрс эсэргүүцсэн хэвээр байв. Тэр ч байтугай 1904 онд улс даяар нийтэлсэн “Айлтган тогтоосон сургуулийн дүрэм” (Гуймао сургалтын тогтолцоо)-д “Хятад болон барууны хоорондох ёс зүй, зан заншлын ялгаа нь охидын сургууль, охидын багшийн сургууль байгуулахад тохиромжгүй” (Шу Шинчен, 1961, х. 202) гэж онцолсон байдаг. Тэрээр “Хятадын өнөөгийн нөхцөл байдалд охидын сургууль байгуулах нь олон сөрөг талтай бөгөөд туйлын зохисгүй” (Шу Шинчен, 1961, х. 385) гэж үзжээ. Манж Чин улсын засгийн газрын янз бүрийн хориглолын доор анхны охидын сургууль Жинзэн нь 1898 онд Шанхайд байгуулагджээ. Гэсэн ч байгуулагдаад жил ч бололгүй Манж Чин улсын засгийн газраас үндэслэлгүй хэргээр сургуулийн үйл ажиллагааг зогсоосон нь тухайн үед Хятад улсад эмэгтэйчүүдийн боловсролыг хөгжүүлэхэд хэцүү байсныг харуулж байна. Хятадын хамгийн анхны орчин үеийн охидын сургууль нь 1901 онд байгуулагдсан Сужоу дахь Ланлин охидын сургууль юм. Дараа нь Гуанжоу, Шанхай¹ болон бусад газарт охидын сургуулийг байгуулжээ. 1903 онд Өвөр Монголын Харчин баруун хошууны ван Гүнсэньноровын үүсгэн байгуулсан “Төвийг хүмүүжүүлэх охидын сургууль” нь Хятад улсын орчин үеийн түүхэн дэх анхны охидын сургуулийн нэг төдийгүй Монгол үндэстний боловсролын түүхэн дэх анхны охидын сургууль (Ван Фэнлэй, 2013, х. 792) юм.

Энэхүү өгүүлэлд “Төвийг хүмүүжүүлэх охидын сургууль”-ийн дүрэм, хичээлийн хуваарь, шалгалтын дүн зэрэгт шинжилгээ хийж, тус сургуулийн сургалтын бодит байдлыг тодорхойлохыг зорилоо.

1. ТӨВИЙГ ХҮМҮҮЖҮҮЛЭХ ОХИДЫН СУРГУУЛЬ БАЙГУУЛАГДСАН НЬ

Гүнсэньноров (1872-1931) нь Манж Чин улсын сүүлч Дундад иргэн улсын эхний үеийн монгол ван юм. Тэрээр Өвөр Монголын Зостын чуулганы Харчин баруун хошууны (одоо ӨМӨЗО-ны Улаанхад хотын Харчин хошуу) язгууртны гэр бүлд төржээ. Чингис хааны гавьяат баатар Залмын хойч, Зостын чуулганы дараа Харчин баруун хошууны засаг чин ван Вандаднамжилын ууган хөвгүүн юм. 1898 оны 4 дүгээр сард Вандаднамжил өвчний улмаас нас барж, Гүнсэньноров 1899 оны хавар вангийн ширээг албан ёсоор өвлөн авчээ (Жан Гүочян, 2001, х. 49).

1903 оны 3 дугаар сард Гүнсэньноров Японы Манж Чин улсын элчин сайд Үчида Косайгийн тусламжтайгаар Хааны ордны шадар сайд Халхын Наянт чин вангийн хөвгүүн Ци Ченву, Со чин ван Шан Чигийн ууган хөвгүүн Шиан Жан нарын хамтаар зүүн тийш Япон улс руу морджээ. Осака хотод болсон аж үйлдвэрийн үзэсгэлэнг сонирхон, японы улс төр, аж үйлдвэр, боловсрол, зэвсэг техник зэрэгтэй танилцжээ. Мөн Японы Жиссен охидын сургуулийн захирал Шимода Утакотой уулзсанаар эмэгтэйчүүдийн боловсролын чухал чанарыг ойлгон, Хятадад буцаж ирэн охидын болон цэргийн сургууль байгуулахаар бэлтгэж байв (Бу Энхэ, Шин Фули, 1986, х. 18). Шимода Утако (1854-1936) бол Японы орчин үеийн эмэгтэйчүүдийн боловсролын салбарт тэргүүлэгч хүн юм. 1885 онд тэрээр Язгууртны охидын сургуулийн декан, профессор болсноор язгууртны боловсролын салбарт 20 гаруй жил ажиллаж, 1898 онд “Эзэн хааны эмэгтэйчүүдийн нийгэмлэг” байгуулж, “Японы эмэгтэйчүүд” сэтгүүл эрхэлжээ. 1899 онд Жиссен охидын сургууль байгуулав (Шимода Утако, 1945, х. 745-773).

Гүнсэньноровын гаргасан зарлигт Япон улсын хөгжил цэцэглэлтийн шалтгааныг шинэ боловсрол гэж хураангуйлж, сургууль байгуулах нь үндэсний сэргэн мандалт, улс орны хөгжил цэцэглэлтэд

¹ 1902 онд Гуанжоу хотод Гүни охидын сургууль, Шанхай дахь Вубен охидын сургууль, Шанхай дахь Ангүо охидын сургууль

чухал ач холбогдолтой талаар, эмэгтэйчүүдийн соёлын чанарыг дээшлүүлэхийн тулд охидын сургууль байгуулах, хүүхдүүдийг бага наснаас нь эхийн хүмүүжил хүртээх, ард түмний соёлын хэв чанарыг нийтэд нь дээшлүүлэх хэрэгтэй талаар дурджээ. Сургуулийн насны охид, залуучуудыг засаг яаманд бүртгүүлж, эмэгтэйчүүдийн болон цэргийн сургуульд тус тус элсүүлэхийг ард түмэнд тушаажээ. Зарлигт “Хүүхдүүд ээжийнхээ боловсрол, хүмүүжилд найдаж өсдөг. Тэд ээжийнхээ зан чанар, үг яриа, үйл хөдлөлийг дуурайх дуртай. Эх нь боловсролтой байж чадвал хүүхдэдээ бичиг үсэгт сургах, эрүүл ахуй гэх мэт сургуульд орохын өмнөх боловсролыг олгож, үр хүүхдийн үнэнч борогжуун зан чанар, ахмадаа хүндэтгэх шилдэг зан чанарыг төлөвшүүлэх боломжтой. Сургуульд орсны дараа улс орныхоо төлөө мораль чадвар хосолсон шилдэг авьяаснуудыг хөгжүүлэх боломжтой. Үүнээс үзвэл, улс үндэстний сэргэн мандалт нь ард түмний соёлын сайжралаас, ардын соёлыг дээшлүүлэх нь эхийн боловсролын түвшнээс хамаарна” (Жао Линхай, 2007, х. 54-55) гэж тусгайлан дурдсан байдаг. Гүнсээноров эмэгтэйчүүдийн боловсролын ач холбогдлыг эх хүний үр хүүхдээ хүмүүжүүлэх нь улс орны ирээдүйтэй холбоотой хэмээн гэж тодорхойлодог байжээ.

Гүнсээноров аавынхаа жүжгийн театр болох Яньи танхимыг засварлаж “Төвийг хүмүүжүүлэх охидын сургууль” байгуулжээ. 1903 оны 12 дугаар сарын 28-ны өдөр тус сургуулийн нээлтийн ёслолд Гүнсээноров, хатан Шанкүн зэрэг ордын ойр орчмын хоёр зуу орчим хүмүүс оролцжээ. Тус охидын сургуулийг анх 24 сурагчтай нээсэн бөгөөд сурагчид нь вангийн ордны шивэгчин, ойролцоо амьдардаг түшмэдийн охид байсан. Гүнсээноровын хатан Шанкүн тус сургуулийн захирлаар, япон хатагтай Кавахара Мисако эрхлэгчээр ажиллажээ. Кавахара Мисако (1875-1945) Японы Шиншү Мацүмото домэйны (одоогийн Нагано Мацүмото хот) хүмүүн юм. 1900 оны 8 дугаар сард Шимода Утако Японы Шинэцү мужид лекцийн аялал хийж байхад Кавахара Мисакотой тусгайлан очин золгож, Хятадад очиж багшлах санаагаа хэлжээ. Шимодагийн зөвлөсний дагуу Кавахара 1900 оны 9 дүгээр сард Хятад хүмүүний үүсгэн байгуулсан Ёкохама Дайдо сургуульд багшилжээ. 1902 оны 8 дугаар сард мөн Шимодагийн зөвлөснөөр Кавахара Шанхай руу Вубен охидын сургуульд багшлахаар очжээ. Тэрээр Хятадад багшлахаар очсон анхны япон эмэгтэй багш юм. Вубен охидын сургуульд жил илүү багшилсны эцэст Шанхай дахь Япон улсын ерөнхий консул Одагиригийн зөвлөснөөр 1903 оны 12 дугаар сард Өвөр Монголын Харчин баруун хошууны вангийн ордны “Төвийг хүмүүжүүлэх охидын сургууль”-д шилжин очиж эмэгтэйчүүдийн боловсролын үйл ажиллагаанд оролцсон юм (Мисако Ичиномия, 1909, х. 1-27, х. 68, х. 97-99, х. 141-149; Зоригт, 2008, х. 11-16).

Төвийг хүмүүжүүлэх охидын сургууль байгуулагдсан нь монгол үндэстний эмэгтэйчүүдийн боловсролын шинэ замыг нээсэн байна.

2. СУРГУУЛИЙН ДҮРЭМ

Төвийг хүмүүжүүлэх охидын сургуулийн дүрмийг (Мисако Ичиномия, 1909, х. 149-155; Мисако Кавахара, 1969, х. 203-209; ӨМБОЗ, 1995, х. 274-278) япон эмэгтэй багш Кавахара Мисако зохион бичиж, Гүнсээноров хятад хэл рүү орчуулжээ. Уг дүрэм нь сургалтын зорилго, хичээл, хичээлийн жил, улирал, ажилтан, санхүү, шалгалт, урамшуулал, шийтгэлийн тогтолцоо, амралт, хувцас гэх мэт 17 хэсэг, 30 зүйл заалттай. Сургуулийн дүрэм нь охидын сургуулийн онцлогийг тодорхой хэмжээгээр тусгасан байдаг тул заримыг нь иш татаж, дүн шинжилгээ хийлээ.

2.1. Сургалтын зорилго

“Эрдэм мэдлэгийг хөгжүүлэн, бие махбодыг чийрэгжүүлж, эрхэмсэг зан чанарыг төлөвшүүлэн, ариун журмын үндэс суурийг тавих” сургалтын зорилго тавьсан байна. Сургалтын зорилго нь бие бялдар, оюун санааны хувьд эрүүл, гэр бүл, нийгэмд хэрэгтэй шинэ эмэгтэйчүүдийг төлөвшүүлэхэд оршино. Энэ зорилго нь Японы “Язгууртны охидын сургуулийн дүрэм” (Японы Үндэсний Архив Дижитал Архив, Анги 00663100, 1893)-ийн сургалтын зорилготой үндсэндээ төстэй байна.

2 дугаар зүйл: Тус сургуулийн сургалтын зорилго нь эрдэм мэдлэгийг хөгжүүлж, эрхэмсэг зан чанарыг төлөвшүүлэх, бие махбодыг чийрэгжүүлэх, дээд давхаргын сайн эхнэр, ухаалаг ээж болох хүмүүсийг төлөвшүүлэхэд оршино.

Язгууртны охидын сургууль 1885 онд хааны угсаатан, язгууртны охидод зориулж тэднийг шинэчлэх, баруунжуулах зорилгоор хааны хатны зарлигаар байгуулагдсан, хааны ордны дотоод яамны сайдын харьяанд байсан төрийн боловсролын байгууллага юм. Харин 1889 онд энгийн охидыг элсүүлэхийг зөвшөөрсөн (Миса Манабе, 2006, х. 43-60) байна.

2.2. Хичээлийн төрөл

“Төвийг хүмүүжүүлэх охидын сургууль”-ийн дүрэмд биеийг засах, монгол хэл, хятад хэл, япон хэл, түүх, газарзүй, тоо бодлого, байгалийн шинжлэх ухаан, зураг, гэрийн явдал, оёдол, дуу хөгжим, биеийн тамир гэсэн 13 хичээлийн багцыг дурджээ. Такама Кенчу, Бүрцэцэг (2010, х. 11) нар хичээлийн багц нь Японы охидын бага сургуультай бараг адилхан бөгөөд “Төвийг хүмүүжүүлэх охидын сургууль”-д хэрэгжүүлэхээр оролдсон гэжээ. Бао Жинхуа (2013, х. 72) нь “Төвийг хүмүүжүүлэх охидын сургууль”-ийн хичээл нь Японы охидын ахлах сургуулийн хичээлд суурилсан байх магадлал өндөр гэж үзжээ.

Тэгэхээр “Төвийг хүмүүжүүлэх охидын сургууль”-ийн хичээлийг юуны үндсэн дээр загварчилсан бэ? гэсэн асуулт гарна. Тус сургуулийн хичээлийг Японы Язгууртны охидын сургуульд заадаг хичээлтэй харьцуулсныг Хүснэгт 1-д үзүүлэв.

Хүснэгт 1.Төвийг хүмүүжүүлэх охидын сургууль болон Язгууртны охидын сургуулийн хичээл

Хичээлийн нэр	Агуулга	
	Төвийг хүмүүжүүлэх охидын сургууль	Язгууртны охидын сургууль
Биеийг засах	Сурах бичиг, Зааж өгөх	Ёс суртахууны хураангуй
Монгол хэл (Т) Улсын хэл (Я)	Ярих ба унших, Үг бүтээх, Зохион бичих, Хэлний зүй	Унших, Зохион бичих
Хятад хэл	Ярих ба унших, Үг бүтээх, Зохион бичих, Хэлний зүй	Ярих ба унших
Япон хэл (Т) Европ хэл (Я)	Унших, Ярилцаа, Зохион бичих, Хэлний зүй	Унших, Орчуулан тайлбарлах, Бичих, Ярилцаа, Хэлний зүй
Түүх	Хятадын түүх, Гадаад түүх	Японы түүхэн домог, Японы түүх, Гадаад түүх
Газарзүй	Хятадын газарзүй, Гадаад газарзүй	Японы газарзүй, Гадаад газарзүй, Газрын байдал
Тоо бодлого	Сампин бодлого, Бийр бодлого	Нэмэх, хасах, үржүүлэх, хуваах, Бутархай, Аравтын бутархай, Пропорц, Хувийн тооцоо...
Байгалийн шинжлэх ухаан	Байгалийн түүх, Эрүүл манд, Физиологи	Хими, Физик, Байгалийн түүх, Физиологи
Зураг	Чөлөөт зураг (Үнэгүй зураг)	Харандаан зураг, Хятад зураг, Барууны зураг
Гэрийн явдал	Ёс зүй, Хувцас, Өмсгөл засал, Зууш хийх, Хоол хүнс, Орон сууц, Үйлчлэх, Данс тэмдэглэл, Сувилах, Хүүхэд асрах	Ёс зүй, Хоол хүнс, хувцас, орон сууц, Нярав, Сувилах, Хүүхэд асрах, Үйлчлэх
Оёдол	Оёх, Зүсэх, Дуусгах, Эвхэж хураах	Оёх, Хувцас
Дуу хөгжим	Дуулах, Дульцимер	Дуулах, Ятга, Дульцимер
Биеийн тамир	Тоглоом, Ерөнхий биеийн тамир	Тоглоом, Ерөнхий биеийн тамир
Бодит зүйл	—	Энгийн амьтан, ургамал, Энгийн байгалийн болон хиймэл бүтээгдэхүүн, Энгийн байгалийн бүтээгдэхүүн, үзэгдэл
Уран бичлэг	—	Катакана, Хирагана, Хичээнгүй бичлэг, Гүйлгэн бичлэг, Таталган бичлэг

Хүснэгтээс харахад хоёр сургуулийн хичээл, сургалтын агуулга нь үндсэндээ адилхан боловч Язгууртны охидын сургуульд “Бодит зүйл”, “Уран бичлэг”-ийн хичээл илүү байна. Тухайн үеийн Японы бага сургууль, охидын ахлах сургуулиудад “Бодит зүйл” нь байгалийн шинжлэх ухааны хичээлд багтдаг байв (Боловсролын түүхийн эмхэтгэлийн холбоо, 1938, х. 41, х. 223). “Уран

бичлэг”-ийн хичээл нь “Төвийг хүмүүжүүлэх охидын сургууль”-ийн дүрэмд тусгагдаагүй ч үнэн хэрэгтээ танхимын хичээлд ордог байв. (Хүснэгт 3, Хүснэгт 4, Хүснэгт 5, Хүснэгт 6-г үзнэ үү)

2.3. Японы Язгууртны охидын сургуулийн дүрмийг нэвтрүүлсэн нь

Дээр дурдсанаар “Төвийг хүмүүжүүлэх охидын сургууль”-ийн дүрэм нь сургалтын зорилго, хичээл, хичээлийн жил, улирал, ажилтан, санхүү, шалгалт, урамшуулал, шийтгэлийн тогтолцоо, амралт, хувцас гэх мэт 17 хэсэг, 30 зүйл заалттай. Японы Язгууртны охидын сургуулийн дүрэм нь ерөнхий дүрэм, хичээл, дэвших ба гэрчилгээ, хичээлийн жил ба амралт, элсэлт/гарах ба тасалдах, сургалтын төлбөр, сурагчийн удирдамж гэх мэт 7 бүлэг, 34 зүйл заалттай байдаг. Хоёр сургуулийн дүрмийн ижил төстэй агуулгын харьцуулалтыг Хүснэгт 2-т үзүүлэв.

Хүснэгт 2. Төвийг хүмүүжүүлэх охидын сургууль болон Язгууртны охидын сургуулийн дүрэм

Төвийг хүмүүжүүлэх охидын сургуулийн дүрэм	Язгууртны охидын сургуулийн дүрэм
1 дүгээр зүйл. Эрдэм мэдлэгийг хөгжүүлэн, бие махбодыг чийрэгжүүлж, эрхэмсэг зан чанарыг төлөвшүүлэн, ариун журмын үндэс суурийг тавих.	2 дугаар зүйл. Тус сургуулийн боловсролын зорилго нь эрдэм мэдлэгийг хөгжүүлж, эрхэмсэг зан чанарыг төлөвшүүлэх, бие махбодыг чийрэгжүүлэх, дээд давхаргын сайн эхнэр, ухаалаг ээж болох хүмүүсийг төлөвшүүлэхэд оршино.
3 дугаар зүйл. Хичээл төрлийн хуваагдал нь дараах мэт: Биенийг засах, Монгол хэл, Хятад хэл, Япон хэл, Түүх, Газарзүй, Тоо бодлого, Байгалийн шинжлэх ухаан, Зураг, Гэрийн явдал, Оёдол, Дуу хөгжим, Биений тамир	9 дүгээр зүйл. Бага, дунд сургуулийн хичээл төрөл, хичээлийн цагийн хуваарилалт дараах мэт: Улсын хэл, Хятад хэл, Европ хэл, Түүх, Газарзүй, Тоо бодлого, Байгалийн шинжлэх ухаан, Зураг, Гэрийн явдал, Оёдол, Дуу хөгжим, Биений тамир, Бодит зүйл, Уран бичлэг
9 дүгээр зүйл. Баян ядуу ялгалгүй, хүмүүжилтэй, бие цархираг, охидыг сонгох эрхтэй.	3 дугаар зүйл. (Сурагч) хүмүүжилтэй, бие бялдраа хөгжүүлж, суралцахыг тэсвэрлэж чаддаг язгууртан удмын охид байх ёстой. Гэсэн хэдий ч нөхцөл байдлаас шалтгаалан самрай, энгийн иргэдийн охидыг элсүүлэхийг зөвшөөрнө.
12 дугаар зүйл. Төгсөгчдөд төгсөлтийн гэрчилгээ олгоно.	15 дугаар зүйл. Бага, дунд сургуулийн ангийн суралцагчдын дүн тэнцэгчдэд төгсөлтийн гэрчилгээ олгоно.
15 дугаар зүйл. Сурагчдыг сургуулиас гарахыг хориглоно. Зайлшгүй нөхцөл байдал үүссэн тохиолдолд гэр бүлийн гишүүд нь сургуульд өргөдөл гарган, захирлын зөвшөөрлөөр сургуулиас гарч болно.	24 дүгээр зүйл. Сурагчдыг сургуулиас гарахыг хориглоно. 25 дугаар зүйл. Сурагчид хичээл таслахыг хориглоно. Өвчний болон бусад ослын улмаас хичээл таслах эсвэл хоцрохоор бол батлан даагч, эцэг эх, асран хамгаалагч нь тухайн өдөр өргөдөл гарган мэдэгдэх ёстой.
19 дүгээр зүйл. Бүгд хөх даавуун дээл өмсөж, ... гадаад төрхөө гайхуулж болохгүй.	34 дүгээр зүйл. Хувцас нь энгийн, биед тохирсон байх ёстой бөгөөд гадаад төрхөө өрсөлдөж, гялалзсан хувцас өмсөхөөс зайлсхийх хэрэгтэй.
23 дугаар зүйл. Сурагчид зөв шударга, чармайлттай байж, эелдэг зөөлөн, чигч шударга эмэгтэйн сайн чанарыг төлөвшүүлэх ёстой.	31 дүгээр зүйл. Сурагчид хааны хатны зарлигийг ямагт дагаж мөрдөж, зөв шударга, чармайлттай байж, эелдэг зөөлөн, чигч шударга эмэгтэйн сайн чанарыг төлөвшүүлэх ёстой.
24 дүгээр зүйл. Өдрийн дундаж эе найртай, итгэлтэй байж, сургуулийн дүрэм, багшийн сургаалыг чанд дагаж мөрдөх ёстой.	32 дугаар зүйл. Өдрийн дундаж эе найртай, итгэлтэй байж, сургуулийн дүрэм, уриаг чанд сахих ёстой.
25 дугаар зүйл. Даруухан хооллож, илүү биений тамирын дасгал хийх хэрэгтэй.	33 дугаар зүйл.

	Үргэлж даруухан хооллож, тохирсон хэмжээний биеийн тамирын дасгал хийж, бие бялдар, оюун санааны эрүүл мэндийг сахихыг хичээх ёстой.
--	--

Хүснэгтээс харахад зорилго болон хичээлээс гадна сургуулийн элсэлт, төгсөлтийн гэрчилгээ, сургуулиас завсарлах, хувцас, ёс зүй, хооллолт, биеийн тамирын хөдөлгөөн гэх мэт үндсэндээ ижил шаардлагатай байна

2.4. Сургалтын тогтолцоо, сургалтын хугацаа

“Төвийг хүмүүжүүлэх охидын сургууль”-ийн дүрэмд энгийн салаа 4, ахлах салаа 4, нийт 8 жил суралцахаар тогтоожээ. Үүнээс гадна хичээлийн чадвар дутмаг байгаа суралцагчдад нэмэлт цаг гаргаж, тэдний хоцрогдлыг нөхөх, дараагийн түвшний сургалтын шаардлагыг хангахад нь дэмжлэг үзүүлэх зорилгоор тусгай салаа, нөхөн сурах салаа бий болгожээ. Энгийн салаа 4 жил, ахлах салааны 4 жилийн сургалтын тогтолцоо нь тухайн үеийн Японы энгийн бага сургууль, ахлах бага сургуультай ижил байна (Боловсролын түүхийн эмхэтгэлийн холбоо, 1938, х. 39). Язгууртны охидын сургуулийн дүрмийн 4 дүгээр зүйлд энгийн бага сургууль, ахлах бага сургуулийн хичээл тус бүр 3 жил үргэлжилнэ гэж заасан байдаг. 1902 онд Манж Чин улсын засгийн газраас боловсруулсан “Зарлигаар тогтоосон сургуулийн дүрэм” (Реньин сургалтын тогтолцоо)-д энгийн бага сургууль 3 жил, ахлах бага сургууль 4 жил хичээллэнэ (Шу Шинчен, 1961, х. 404) гэж заасан байдаг. 1904 онд нийтэлж, хэрэгжүүлсэн “Айлтган тогтоосон сургуулийн дүрэм” (Гуймао сургалтын тогтолцоо) нь энгийн бага сургууль 5 жил, ахлах бага сургууль 4 жил үргэлжилнэ (Шу Шинчен, 1961, х. 418, х. 433) гэж заасан байдаг.

“Төвийг хүмүүжүүлэх охидын сургууль”-ийн дүрэмд хичээлийн жилийг 2 дугаар сарын 15-аас 11 дүгээр сарын 15 хүртэл хугацаагаар тогтоосон. Хичээлийн жил 3 улиралтай бөгөөд I улирал нь 2 дугаар сарын 15-аас 5 дугаар сарын 15, II улирал нь 5 дугаар сарын 15-аас 8 дугаар сарын 15 хүртэл, III улирал нь 8 дугаар сарын 15-аас 11 дүгээр сарын 15 хүртэл үргэлжилнэ. Жилийн болон өвлийн амралт нь 11 дүгээр сарын 15-аас 2 дугаар сарын 15 хүртэл байдаг (Мисако Ичиномия, 1909, х. 150, х. 153; Мисако Кавахара, 1969, х. 205, х. 207). Тус сургуулийн гурван улирал бүхий хичээлийн жилийн бүтэц нь Зарлигаар тогтоосон бага сургуулийн дүрэм болон Айлтган тогтоосон бага сургуулийн дүрэмд заасан хоёр улирлын заалтаас ялгаатай боловч Японы гурван улирлын тогтолцоотой ерөнхийдөө төстэй. 1890-ээд оноос японы бага сургуулиуд 4 дүгээр сараас эхэлж, гурван улирал бүхий хичээлийн жилийн бүтцийг 1900 оны орчим хүртэл мөрдсөн (Хидео Сато, 2005, х. 67) байна. Төвийг хүмүүжүүлэх охидын сургуульд улирал хооронд амралт байдаггүй. Жилийн эцсийн болон өвлийн дараалсан амралт олгохдоо Монгол угсаатны зан заншил, Харчин баруун хошууны цаг уурын онцлогийг харгалзан үзсэн байх талтай.

3. ОХИДЫН СУРГУУЛИЙН СУРГАЛТЫН БОДИТ БАЙДАЛ

“Төвийг хүмүүжүүлэх охидын сургууль”-ийн дүрмийн 7 дугаар зүйлд зааснаар сургуулийн хөрөнгийг хошуу албанаас бүрдүүлдэг бөгөөд суралцагчдаас ямар нэгэн төлбөр авахгүй, хэн нэгэн сайн дураараа хандив өргөвөл зохих журмын дагуу сургууль бүртгэн авахаар заасан байдаг.

1907 оны “Боловсролын яамнаас Монгол хошууны охидын сургууль эрхэлсэн тухай айлтгалын бичиг”-т “Төвийг хүмүүжүүлэх охидын сургууль” байгуулагдаад нэгэнт гурван жил болж, илт үр бүтээмж олжээ. Гүнсэnnоровын хатан, эх, долоодугаар охин дүү нар хандивлаж байгуулсан гэж дурдсан бөгөөд Монгол орны хэв суртал харахан нээгдээгүй тул сургууль байгуулахад ер нь тийм амар биш, охидын сургуулийг нээхэд нэн ч хүндрэлтэй юм. Тус сургуулийн үйл ажиллагааг сурталчилж, Монгол оронд сургууль байгуулахыг дэмжихийн тулд, дуурайл болгон шагнал олгохыг хүсжээ (Жу Ючин, 1987, х. 289-230).

Охидын сургуулийн бүх төлбөрийг албанаас төлдөг бөгөөд суралцагчдын ар гэрийнхэн ямар ч зардал гаргадаггүй. Гүнсэnnоров аль болох олон хүүхэд элсүүлэхийн тулд хичээлийн хэрэгсэл, өдрийн хоолыг үнэ төлбөргүй өгөх зэрэг олон төрлийн дэмжлэгийн арга хэмжээ авах төдийгүй

ордноос хол байгаа суралцагчдыг сүйх тэргээр хангаж байв (Мисако Ичиномия, 1909, х. 159-160; Мисако Кавахара, 1969, х. 213).

3.1. Хичээлийн хуваарь

1905 оны 3 дугаар сарын 21-ээс 10 дугаар сарын 15 хүртэлх “Төвийг хүмүүжүүлэх охидын сургууль”-ийн хичээл (Мисако Ичиномия, 1909, х. 170-172; Мисако Кавахара, 1969, х. 221-223)-д 10:00 цагаас эхэлж 15:50 цагт дуусдаг хуваарьтай байжээ. Хичээл бүр 50 минут үргэлжилж 10 минут завсарлаж, үдийн хоолны цаг 11:50-13:00 хүртэл байдаг. Бямба гаргийн үдээс хойш болон ням гарагт амардаг байна. Хичээлийн хуваарьд сургуулийн дүрэмд заагаагүй "уран бичлэг"-ийн хичээл орсон байна.

Хүснэгт 3. Сургалтын төлөвлөгөө /7 хоногт үзэх цаг/

Анги \ Хичээл	Биеийг засгах	Монгол хэл	Хятад хэл	Япон бичиг	Япон хэл	Тоо бодлого	Түүх	Газарзүй	Уран бичлэг	Биеийн тамир	Зураг	Дуу	Давлалта	Гэрийн явдал	Нэхмэл
Тэргүүн анги	1	3	2	2	2	2	1	1	3	2	2	2	2	1	1
2 дугаар анги	2	3	3	2	2	3	--	--	3	2	2	2	2	--	1
3 дугаар анги	2	4	3	2	2	2	--	--	2	2	2	2	2	--	1

Сургалтын төлөвлөгөөнөөс дараах онцлогуудыг ажиглаж болно. Нэгдүгээрт, анги болгонд заадаг хичээл өөр байна. Тэргүүн анги газарзүй, түүх, гэрийн явдал хичээл ордог бол 2, 3 дугаар ангид ордоггүй. Хоёрдугаарт, нэг хичээлийн хувьд ч гэсэн өөр өөр ангид үзэх цаг ялгаатай байдаг. Гуравдугаарт, япон хэлний хувьд “Япон бичиг” болон “Япон хэл” долоо хоногт 4 цаг орж байгаа нь нийт хичээлээс Япон хэлийг онцолж буйг харуулж байна. Мэйжигийн үед япон хэлийг ярианы хэл, бичгийн хэл гэж ялгагдах тул тухайн үеийн Хятад улсад ярианы хэлийг “Зүүний хэл” буюу “Япон хэл”, бичгийн хэлийг “Зүүний бичиг” буюу “Япон бичиг” (Зоригт, 2008, х. 26) гэж нэрлэдэг байжээ.

3.2. Шалгалтын оноо

Төвийг хүмүүжүүлэх охидын сургууль нь шалгалтыг их, бага шалгалт гэсэн 2 төрөлд хувааж, их шалгалтыг хичээлийн жил бүрийн эцэст авч, шалгалтад тэнцсэн хүмүүсийг ахиулна. Бага шалгалтыг улирал бүрийн төгсгөлд шалгаруулж, оноог нь үндэслэн суралцагчийг жагсаадаг байжээ (Мисако Ичиномия, 1909, х. 152; Мисако Кавахара, 1969, х. 206). Онооны жагсаалтад үндэслэн суралцагчдад зохих шагнал олгодог бөгөөд энэ нь цаашид ололт амжилтынхаа төлөө хойрго биш, илүү их хичээнгүй суралцахыг урамшуулахын төлөө байжээ (Японы үндэсний архивын Азийн түүхийн материалын төвийн Дижитал архив, 1907, Лавлах код: B04011142500, х. 998).

1904 оны “Төвийг хүмүүжүүлэх охидын сургууль”-ийн I улирлын тэргүүн анги, 2 дугаар ангийн шалгалтын оноог Хүснэгт 4-д, II улирлын 3 дугаар ангийн шалгалтын оноо Хүснэгт 5-д, III улирлын тэргүүн анги, 2 дугаар ангийн шалгалтын оноог Хүснэгт 6 (Өвөр Монголын Улаанхад хотын Харчин хошуу дахь "Чин гүрний үеийн Монгол вангийн ордон музей"-д хадгалж буй, Зохиогч)-д тус тус үзүүлэв.

Хүснэгт 4. 1904 оны I улирлын шалгалтын оноо. Бадаргуулт төрийн 30 дугаар оны 5 сарын 14

Хичээл	Япон бичиг	Япон хэл	Тоо бодлого	Уран бичлэг	Дуу	Нэхмэл	Нийт оноо	Дундаж оноо	Жагсаалт
Тэргүүн анги									
Ланжэн	93	90	50	91	90	93	507	84	1
Жинпин	94	90	43	93	92	95	507	84	1
Шүйшиан	87	92	65	88	91	85	507	84	3

Жинду	92	90	50	88	90	87	497	83	4
2 дугаар анги									
Баожэн	93	93	80	88	90	90	540	90	1
Юймэй	95	97	70	78	94	83	517	86	2
Чуньэр	94	96	65	82	89	90	516	86	3
Хайхуа	83	87	70	88	90	90	508	84	4
Юэүр	88	91	80	79	89	80	506	84	5
Чиуэр	90	92	65	80	90	80	497	82	5
Лиотү	76	77	80	79	90	90	492	82	7
Юүжэн	89	60	95	78	89	73	484	80	8
Юээр	79	74	80	78	85	74	470	78	9
Шэнэр	64	60	80	79	89	86	458	76	10
Шүжэн	79	69	20	78	87	82	415	69	11
Линлун	82	63	0	88	89	73	395	65	12
Лиуяе	58	26	60	82	87	75	388	64	13
Зуйэр	58	33	30	78	85	70	354	59	14
Гүйхуа	62	37	0	78	82	65	324	54	15
Шоуэр	Өвчтэй								
Шиэр	Өвчтэй								

Хүснэгт 5. 1904 оны II улирлын шалгалтын оноо

Хичээл	Монгол хэл	Хятал хэл	Япон хэл	Ярилцаа	Тоо боллого	Зураг	Уран бичлэг	Нэхмэл	Дуу	Нийт оноо	Дундаж оноо	Жагсаалт	
												I улирал*	II улирал*
3 дугаар анги													
Лижэн	6	9	10	9	10	9	7	9	9	83	9	1	1
Лиэр	4.5	8	8.5	9	9	9	6	9	9	72	8	2	2
Чинюн	8.5	6	7	9	10	8	3.5	9	8	69	7.7	3	3
Лянши	3	6	9	9	10	8	5.9	9	9	68.9	7.7	4	4
Дайэр	байхгүй												
Цайшиа	4	5	7	8	4	8	4.2	7	7	59.2	6.6	6	8
Шилиу	5	5	8	9	9	7	3.3	8	9	63.3	7	7	6
Лянжэн	1	5	9	9	10	8	1	7.5	9	61.5	6.8	8	7
Дайшяо	2	5	9	9	10	8	4.5	8.5	8.5	64.5	7.2	9	5
Хуйшян	1.5	4	8	9	6	7	2.5	9	8	55	6.1	10	12
Хуаэр	1	5	8	9	7	8	5.3	8	8.5	59.8	6.6	11	9
Рунчун	1	1	8	6	9	5	0	7	8.5	45.5	5	12	15
Шухуй	1	4	8.5	9	9	7	0	8	9	55.5	6.2	13	11
Чиюэ	1	4	8	9	8	6	1	8	9	54	6	14	13
Чююн	2	3	8	9	9	7	3.5	8.5	9	59	6.5	15	10
Жинхуа	0.5	3	8	6	2	6	0	--	8.5	34	4.2	16	17
Шианю	1	3	7	6	0	6	1	--	8	32	4	17	18
Шижиао	1	4	8	5	7	6	4	--	8.5	45.5	5.6	18	14
Хайтан	0.5	1	0	4	2	7	1.5	--	7.5	23.5	3	19	20
Нонтан	0.5	3	4	6	0	6	0	--	7.5	27	3.4	20	19
Шиалян	0.5	2	0	4	2	4	0	--	8	20.5	2.6	21	22
Инхуа	0.5	1	7	7	5	6	0	--	8	34.5	4.3	22	16
Лиуэр	0.5	2	3	4	0	5	0	--	8	22.5	2.8	23	21
Таоэр	0.5	2	2	3	0	5	0	--	8	20.5	2.6	24	23
Жинфэн	0.5	1	2	4	0	3	0	--	8	18.5	2.3	25	24
Шиюэ	0.5	0	2	4	0	3	0	--	7.5	17	2.1	26	25

Хүснэгт 6. 1904 оны III улирлын шалгалтын оноо. Бадаргуулт төрийн 30 дугаар оны 11 сар

Хичээл	Биеийг засах	Түүх	Газарзүй	Эрүүл мэнд	Монгол хэл	Хятад хэл	Япон бичиг	Ярилцаа	Тоо бодлого	Зураг	Уран бичлэг	Нэхмэл	Дуу	Нийт оноо	Дундаж оноо	Жагсаалт		
																I улирал*	II улирал*	III улирал*
Тэргүүн анги																		
Ланжэн	8	6	9	10	8.5	7	9	10	8	9	7.5	10	9	111	8.6	1	1	1
Жинпин	10	3	10	9	8.5	8.5	8.5	10	7	9	5	10	9	107.5	8.2	2	2	2
Шужин	10	0	8	3	7.5	7	9.5	10	7	7.5	8.5	9	9	96**	7.4	4	3	3
Шүйшиан	8	4	4	0	5	4	9	9	7	7	6.5	9	9	81.5	6.2	3	4	4
2 дугаар анги																		
Баожэн	3	-	-	-	6	7	9	9.5	9.5	7	6	10	9	76	7.6	1	1	3
Чуньэр	10	-	-	-	6	8.5	9.5	10	9.5	7	5.5	10	9	85	8.5	3	2	1
Юймэй	10	-	-	-	4	5	9	10	10	5	7	8	9.5	77.5	7.8	2	3	2
Алин	0	-	-	-	3.5	6	7.5	9	8	5	5	9	7	61	6.1	4	4	6
Шэнэр	0	-	-	-	5.5	5.5	5	7	7	8	4	8	8.5	55.5	5.6	9	5	7
Юүжэн	1	-	-	-	1.5	2	7	7	9	4	3.5	7	9	51	5.1	7	6	11
Чиуэр	10	-	-	-	3	4.5	8.5	10	8.5	5	8	9	9	70.5	7.1	5	7	4
Шүжэн	10	-	-	-	1	2.5	8.5	8.5	8.5	6	4.5	8	9	66.5	6.7	10	8	5
Жуанэр	8	-	-	-	1	0	6	6	5	6	4.5	9	8	53.5	5.4	6	9	9
Юээр	1	-	-	-	1.5	1.5	6.5	6	8	3	1	8.5	8	45	4.5	8	10	12
Линлун	0	-	-	-	9	0	6.5	6	9	5	6.5	3.5	8	53.5	5.4	11	11	10
Шиэр	0	-	-	-	6	1	5	4	7	5	9.5	9	9	55.5	5.6		12	8
Лиуяе	0	-	-	-	4	2	5	5	2	3	3	8	8	40	4	12	13	14
Шоуэр	0	-	-	-	5	3	5.5	4.5	2	4	5.3	8	8	45.3	4.5		14	13
Зуйэр	0	-	-	-	1	0	3	3	2	5	3.2	7.5	8	31.7	3.2	13	15	15
Гүйхуа	0	-	-	-	3.5	0	2	2	2	3	3.4	7	7	29.9	3	14	16	16

Жич: * Зохиогч нэмсэн ** Эх гар бичмэлд "9.6" гэж бичсэн бөгөөд зохиогч үүнийг "96" болгон зассан байна.

Дээрх 3 шалгалтын дүнгээс дараах онцлогийг ажиглаж болно.

1. Төвийг хүмүүжүүлэх охидын сургуулийн анхдагч шалгалтын (хүснэгт 4) хичээлийн агуулгын дагуу уран бичлэгээс бусад бүх хичээлийг Япон эмэгтэй багш Кавахара Мисако заадаг байжээ (Мисако Ичиномия, 1909, х. 171; Мисако Кавахара, 1969, х. 222). Энэ нь сургуулиа яаран нээсэн, бусад хичээл заахад тохиромжтой багш нарыг цаг тухайд нь ажилд авч чадаагүйтэй холбоотой байж болох юм. Кавахара Мисако “Харчин вангийн хатан бид хоёр- Монгол үндэстний зүрх сэтгэлд амилсан эмэгтэй багш” номдоо, “Бээжингээс есөн өдрийн сүйх тэргээр аялалд гараад нэг ч өдөр амарсангүй шууд бэлтгэлээ эхлэв. Долоо хоногийн дараа охидын сургуулийг эхлүүлэх гэж оролдох нь хэдийгээр яаруу, гэнэтийн үйлдлүүд байгаа ч сургууль эхлүүлэхийг яаравчлан, бусад бэлтгэх зүйлийг аажмаар сайжруулах талаар бодож байсан” (Мисако Кавахара, 1969, х. 197) гэжээ.

2. II улиралд монгол хэл, хятад хэл, зураг, III улиралд биеийг засах, түүх, газарзүй, эрүүл мэнд зэрэг хичээлийг (эрүүл мэнд нь охидын сургуулийн байгалийн шинжлэх ухааны хичээлийн нэг. Хүснэгт 1-ээс үзнэ үү) нэмж заадаг.

3. Сурагчид бүгд хятад нэртэй байсан нь тухайн үеийн Харчин баруун хошууны монголчууд хятад үндэстний нөлөөнд автаж байсныг шууд харуулж байна.

Бао Жинхуа (2013, х. 76) төвийг хүмүүжүүлэх охидын сургуулийн I улирлын шалгалтын хүснэгт (хүснэгт 4) болон хичээлийн хуваарийг дурдаж, тэргүүн анги нь сурлагаар хамгийн сайн сурагчдаас бүрдсэн биш, хоёрдугаар ангийн хамгийн багадаа 4 сурагч тэргүүн ангийн сурагчдаас илүү сайн суралцсан. Тэргүүн анги вангийн охин дүү Ланжэн зэрэг 4 сурагчтай, гэрийн явдал, газарзүй, түүх зэрэг бусад ангид байхгүй хичээлийг заажээ. Дээрх ажиглалтаас сурагчдыг шалгалтын оноогоор бус харин тэдний нийгмийн байр суурийн дагуу ангийг хуваажээ гэсэн дүгнэлтэд хүрсэн байна. Мэйжи 39 (1906) оны 3 дугаар сарын 3-нд хэвлэгдсэн “Боловсролын ертөнц” сэтгүүл дэх Кавахара Мисакогийн “Монголын боловсролын яриа” гэсэн нийтлэлд, тэр үед дараа нь элсүүлсэн сурагчдыг 3 дугаар ангид суулгаж, өмнөх сурагчдыг шалгалтаар 2 ангид хуваасан (Орчин үеийн Азийн

боловсролын түүхийн судалгааны нийгэмлэг, 2002, 12 дугаар боть, х. 226) гэжээ. Энэхүү мэдээлэл болон хичээлийн хуваарь, шалгалтын онооноос тухай үед “Төвийг хүмүүжүүлэх охидын сургууль” нь ангийг доороос нь дээш 1, 2, 3 гэж хуваадаггүй, харин дээрээс нь доош тэргүүн, 2 дугаар, 3 дугаар анги гэж нэрлэдэг байжээ. Японы Язгууртны охидын сургууль нь ч энгийн бага сургууль, ахлах бага сургуулийн ангийг дээрээс нь доош 1 дүгээр, 2 дугаар, 3 дугаар анги гэж хуваадаг байна (Японы Үндэсний Архив Дижитал Архив, Анги 00663100, 1893).

“Монголын Харчин вангийн хүсэлтээр Японы инженерийн хийсэн тариалан аж ахуй, уурхайн байцаалтын нэг мэдээлэл”-ийн “9 дүгээр бүлэг Харчин вангийн ордны боловсролын байдал”-д дараагийн өрөөнд насаар ах 4 суралцагч байж, тэд бол хамгийн дэвшилтэт сурагч бөгөөд вангийн охин дүү хамгийн шилдэг (Японы үндэсний архивын Азийн түүхийн материалын төвийн Дижитал архив, 1907, Лавлах код: B04011142500, х. 988) нь байсан гэж тэмдэглэгджээ. Элсэлтийн шаардлагын тухайд охидын сургууль нь баян ядуу ялгалгүй хүмүүжилтэй, бие цархираг, охидыг элсүүлнэ гэж тодорхой заасан байдаг. Охидын сургууль эхлэхэд Гүнсэнооров 20 настай охин дүүтээ торгон хувцасны оронд бусад сурагчийн адил даавуун хувцас өмсөж, адилхан хичээлийн хэрэглэл болон бусад зүйлс ашиглахыг шаардсан байна. Хэрэв дагаж мөрдөхгүй бол сургуульд оруулахгүй гэсэн баримт (Мисако Кавахара, 1969, х. 190) байдаг. Иймээс ордны шивэгчин нар вангийн охин дүүтэй нэгэн зэрэг сургуулийн хагалаагаар ороод зогсохгүй, нэг ширээнд сууж, ижил дүрэмт хувцас өмсөж, тэгш эрх эдэлдэг байжээ. Тухайн үед охидын сургуульд элсэгчдийн насны ангилал харьцангуй ялгаатай, хамгийн бага нь 7-8, хамгийн ахмад нь 23 настай бөгөөд ихэнх сурагч 14-17 настай байжээ (Мисако Ичиномия, 1909, х. 152). Янз бүрийн насны сурагчдын сурах хэрэгцээ, чадварын түвшин өөр байж болох тул насны зөрүү их сурагчдыг нэг ангид хуваах нь тухайн ангид суралцахад нөлөөлнө. Ингээд сурлага сайтай 4 ахмад сурагчийг нэг ангид хуваарилсан бололтой. Товчхондоо, “Төвийг хүмүүжүүлэх охидын сургууль” хүүхдүүдийг ангид хуваарилахдаа нийгмийн байр суурийн байдал гэхээсээ илүү сурлагын амжилт болон насаар нь ангилдаг байжээ.

3.3. Хичээлээс гадуурх үйл ажиллагаа

Сурагчдын сургалтыг бэхжүүлэх, сурах сонирхлыг нэмэгдүүлэх зорилгоор охидын сургууль Япон сургуулийн жишгээр “Ангийнхны ярианы клуб”, “Цэцэрлэгийн үдэшлэг”-ийг зохион байгуулжээ. Эдгээр нь харьцангуй чухал, стандартчилсан хичээлээс гадуурх үйл ажиллагаа бөгөөд зохих дүрэм, журамтай.

Ангийнхны ярианы клубийг сурагчдын оюуны чадавхыг дээшлүүлэх, хэл яриаг хөгжүүлэх зорилгоор сар бүр зохион байгуулж байв. Тус клубт төвийг хүмүүжүүлэх охидын сургуулийн сурагчид гишүүнээр элсдэг бөгөөд ерөнхийлөгч, туслах, нарийн бичгийн дараа, бичээч зэрэг тушаалыг бий болгож сонгуулиар шийдвэрлэх бөгөөд нэг жилийн хугацаатай сонгодог байв. (Мисако Ичиномия, 1909, х. 160-161).

Цэцэрлэгийн үдэшлэгийн зорилго нь хошууны ард түмний найрсаг харилцааг хөгжүүлэх, эцэг эх, ард түмэнд шинэ боловсролыг ойлгуулах, сургуулийн боловсролын үйл ажиллагааг дэмжих явдал юм. Цайны өрөө, жимсний өрөө, сургуулийн үзэсгэлэнгийн танхим, лекцийн тавцан, шинэ хөгжмийн танхим, эртний хөгжмийн танхим, амралтын газар, хоолны газартай. Гүнсэнооров цэцэрлэгийн үдэшлэгт зориулж “Цэцэрлэгийн үдэшлэгийн дуу”, “Баясалд бүлгэмийн дуу”(Мисако Ичиномия, 1909, х. 162-170)-г өөрөө зохиосон юм. Цэцэрлэгийн үдэшлэгийн үеэр эцэг эх, хошууны ардыг урьж, сурагчдын дуулах, бүжиглэх үзүүлбэр, тэдний гэрийн даалгавар, гар сүлжмэл эдлэл зэргийг үзэж сонирхоно. Мөн япон хэлний лекц уншиж, сурагчдын япон хэлний мэдлэгийг дээшлүүлдэг байжээ.

Үүнээс харахад охидын сургуулийн хичээлээс гадуурх үйл ажиллагаа нь олон тооны бөгөөд агуулга нь баялаг байсан байна. Хичээлээс гадуурх үйл ажиллагаа нь хөгжилтэй, уян хатан, бодит байдалд ойртсон практик шинжтэй болж, мэдлэгийг цогцоор нь хэрэгжүүлэхэд анхаарч байлаа. Үйл ажиллагааны агуулга, хэлбэр нь нээлттэй бөгөөд чанартай, сурагчдын дур, сонирхлыг татахуйц байснаараа боловсролын чухал үүргийг гүйцэтгэж иржээ. Юуны өмнө сурагчдын амьдрал, сургалтын үйл ажиллагааг өргөжүүлж, сургууль, нийгэм хоорондын харилцааг ойртуулжээ. Дараа нь сурагчдын сонирхлыг идэвхжүүлж, тэдний давуу талыг хөгжүүлэх, анхдагч сэтгэлгээ, бүтээлч авьяас чадварыг нь төлөвшүүлэхийг эрмэлздэг байжээ.

ДҮГНЭЛТ

Гүнсэnnоров Өвөр Монголд орчин үеийн боловсролын тогтолцоог нэвтрүүлсэн сургууль 3-ыг байгуулж, Монголчуудын боловсролын үйлсэд тууштай зүтгэсэн юм. “Төвийг хүмүүжүүлэх охидын сургууль” нь Монгол үндэстний боловсролын түүхэн дэх анхны охидын сургууль юм. Тус сургуульд нийгмийн гарал угсаа харгалзахгүй элсэх боломжтой бөгөөд сургалтын төлбөр, хичээлийн хэрэгсэл, үдийн хоол зэргийг албаны зардлаар санхүүжүүлж, сурагчдын гэр бүлээс аливаа төлбөр авдаггүй байжээ. Энэхүү бодлого нь эмэгтэйчүүдийн боловсрол эзэмших боломжийг сайжруулж, нийгмийн тэгш байдал, дэвшлийг дэмжихэд тусалдаг.

Төвийг хүмүүжүүлэх охидын сургуулийн дүрмийг түүнийг анх байгуулах үед япон эмэгтэй багш Кавахара Мисако бичжээ. Тус сургуулийн дүрмийг японы Язгууртны охидын сургуулийн дүрмийг үндэслэн боловсруулсан бөгөөд мөн Харчин баруун хошууны боловсролын бодит байдал, нутгийн монголчуудын зан заншил, цаг уур, бусад хүчин зүйлсийг харгалзан үзжээ. Дүрэм нь японы Язгууртны охидын сургуулийнхтай ижил байх шалтгаан нь Шимода Утакотой нягт холбоотой юм. Өмнө дурдсанаар Гүнсэnnоров 1903 онд япон руу явахдаа Шимода Утакогийн танилцуулгыг сонсон эмэгтэйчүүдийн боловсролын чухлыг ойлгож, “Төвийг хүмүүжүүлэх охидын сургууль”-ийг байгуулжээ. Шимода Утако декан, профессор японы язгууртны боловсролын салбарт 20 гаруй жил ажилласан байна. Шимода Хятад-Японы I дайнаас хойш хятад улсад “охидыг сургах” талаар аль хэдийн бодож байсан юм (Шимода Утакогийн намтар, 1945, х. 400). Шимода Утако хятад улсын эмэгтэйчүүдийн боловсролыг хэр зэрэг сонирхож байсныг тухайн үеийн японы улс төрийн тоймч Узаки Рожогийн “Хөрш Хятад улсын хөгжлийг ялгаварлан гадуурхахгүйгээр сурталчилж байсан хүмүүсийг харвал, эрэгтэйгээс Коноэ Казань, эмэгтэйгээс Шимода Утако байсан” (Шимода Утакогийн намтар, 1945, х. 435) гэж хэлснээс ойлгож болно. 1904 оны 11 дүгээр сард Гүнсэnnоровын хатан Шимодад бичсэн захидалдаа танай шавь Кавахара хатагтай гэсэн бөгөөд түүний ажилд орох хугацааг сунгах учрыг найдаж гоёчилсон байдаг (Мисако Ичиномия, 1909, х. 250). Энэ захидлаас Харчинд хүртэл Кавахара Мисако нь Шимодагийн шавь гэдгийг хүлээн зөвшөөрсөн бөгөөд түүний бүрэн эрхийн хугацааг сунгахад Шимодагийн санал хэрэгтэй байсныг харж болно. Кавахарагийн Өвөр Монголын Харчин баруун хошуу дахь боловсролын үйл ажиллагаанд Шимода Утако нөлөөлсөн гэж хэлж болно.

Төвийг хүмүүжүүлэх охидын сургууль нь феодалын уламжлалт сургалтын агуулгыг орчин үеийн шинжлэх ухааны соёлоор сольсон юм. Сургууль нь сурагчдын сурлагын түвшин, насны онцлогоор дээрээс нь доош тэргүүн, 2 дугаар, 3 дугаар анги гэж хуваагдах бөгөөд хичээл, түүнийг судлах цагийн тоог ангийн түвшнээс нь хамааруулж энгийнээс нарийн, гүехнээс гүн рүү гэсэн үе шат бүхий боловсролын зарчмыг агуулж тодорхойлсон байдаг. Мөн хичээл нь долоо хоног бүр өдөрт 5 хичээл, тус бүр 50 минут үргэлжлэх бөгөөд бямба гаргийн үдээс хойш болон ням гарагт завсарлагаатай байдаг. Энэ бүхэн нь тус сургуулийг шинэ сургуулийн цар хүрээ, хэлбэрээр төлөвшиж эхэлснийг харуулж байна.

Өдөр тутам япон хэлний сургалтад хамгийн их хугацаа зарцуулдаг байсан нь тус сургууль нь япон хэлний боловсролд ихээхэн ач холбогдол өгч байсныг илэрхийлж байна. Гэхдээ Кавахара Мисако “Монголд охидын боловсролыг аль болох япон маягаар хөгжүүлэх, энэ газрыг япончлох үндэс суурь болгох үүднээс охидын сургуульд япон хэл, үсгийг заах ажилд урьдаас анхаарч, япон дуу дуулуулах, япон улс байгуулагдсан болон хаан, хатны мэндэлсэн өдрийг амралтын өдөр болгосон бөгөөд өдөр тутмын яриандаа ч Япон улсыг бишрүүлэхийн тулд болгоомжтой ханддаг...” (Мисако Кавахара, 1969, х. 252) гэжээ. Энэ бол япон маягийн боловсрол, соёл, үзэл суртлын аргаар Өвөр Монгол орон дахь нөлөөллийг бэхжүүлэх зорилготой, энэ нь нэг зүйлийн "Оюун санааны эзлэлт"-ийн санааг илэрхийлж байна.

Кавохара Мисакогийн Харчин баруун хошууны боловсролын үйл ажиллагаа нь боловсролын түрэмгийлэл, тэлэлтийн зарим хандлагатай байв. Тухайн үед Гүнсэnnоров япон эмэгтэй багшийг урьж ажиллуулсан нь хятад эмэгтэй багш олж чадаагүй (Шү Фушяан, 2021, х. 50)-тэй холбоотой. Хэдийгээр Гүнсэnnоров япон эмэгтэй багшийг охидын сургуульд багшлуулсан нь их бага ч гэсэн японы нөлөөнд автсантай холбоотой боловч тухайн үед хятад эмэгтэй багш нар алс холоос тухайн орон нутагт очих дургүй байсан. Мэйжи 40 (1907) оны 3 дугаар сарын 5-нд хэвлэгдсэн

“Эмэгтэйчүүдийн ертөнц” сэтгүүлийн Кавахара Мисакогийн дараах япон эмэгтэй багш Торий Кимикогийн “Монголын өөр нэг ертөнц” гэсэн нийтлэлд “Угаасаа Харчин ван бол туйлын соёлт оюун ухаантай, боловсролд маш их дуртай байсан. Тэгэхээр вангийн боловсролын бодлого нь ‘Монголчуудын үндэстний онцлогийг төлөвшүүлэх’ гэсэн зарчим юм ... нөхөр бид хоёрын энд багшилж байгаа сургууль манай улсын бага сургууль шиг, Монгол хэлээр хичээл заадгаас гадна бас япон хэл заадаг ... японы бага сургуульд заадаг дууг зааж өгөхөд тэд маш сайн дуулдаг. Гэхдээ дууг япон хэлээр заах нь зохисгүй гэж ван үзэж байсан тул ‘Цэцэглэжээ Цэцэглэжээ’, ‘Хэлээ зүсүүлсэн бор шувуу’ ба бусад цэргийн дуунуудыг Монгол хэлнээ хөрвүүлэн зааж байна ...” (Орчин үеийн Азийн боловсролын түүхийн судалгааны нийгэмлэг, 2002, 29 дүгээр боть, х. 96-97) гэжээ. Энэ нь Гүнсээноровын боловсролын анхны зорилго нь япон маягийн боловсролыг бүрэн суулгах бус, харин Монголын үндэстний боловсролыг сэргээх байсныг харуулж байна.

Төвийг хүмүүжүүлэх охидын сургуулийн хичээлээс гадуурх үйл ажиллагаа олон төрөлтэй, агуулга нь баялаг байжээ. Эдгээр үйл ажиллагаа нь юуны өмнө сурагчдын амьдралын туршлагыг нэмэгдүүлэх төдийгүй олон нийтийг оролцуулж сургууль, нийгэм хоорондын харилцааг ойртуулж байжээ.


НОМ ЗҮЙ

- Сун Чанлян. (2017). Чин гүрний үеийн япон эмэгтэй багшаагүүдийн дурсгал. Орчин үеийн Хятадын эмэгтэйчүүдийн түүхийн судалгаа No29. Тайвань.
- Жиан Ихуа нар. (1998). Кан Ювэйгийн бүрэн түүвэр. Бээжин: Хятдын ардын их сургуулийн хэвлэлийн хороо.
- Шу Шинчен. (1961). Хятадын орчин үеийн боловсролын түүхэн материалууд, дундад дэвтэр. Бээжин: Ардын боловсролын хэвлэлийн хороо.
- Ван Фэнлэй. (2013). Монголчуудын бүрэн түүх (Боловсролын боть, доорд дэвтэр). Хөххот: Өвөр Монголын их сургуулийн хэвлэлийн хороо.
- Жан Гүочян. (2001). Гүнсээноров ба Улаанхадын орчин үе. Бээжин: Олон улсын Хуавэн хэвлэлийн хороо.
- Ву Энхэ, Шин Фули. (1986). Гүнсээноров. Улаанхад хотын соёл, түүхийн материалын сонгомол (4-р эмхтгэл: Харчны тусгай эмхтгэл). Улаанхад: Улс төрийн зөвлөлгөөний Улаанхад хотын соёл түүхийн материал судлах зөвлөл.
- Жао Линхай. (2007). Соён гэгээрсэн Монгол ван Гүнсээноров (Харчин хошууны соёл, түүхийн материалын 8-р эмхтгэл). Харчин: Хятадын Ардын Улс төрийн Зөвлөлийн Харчин хошууны хороо.
- Өвөр Монголын боловсролын ойллогын зөвлөл. (1995). Өвөр Монголын боловсролын түүхийн материал (2-р эмхтгэл). Хөххот: Өвөр Монголын их сургуулийн хэвлэлийн хороо.
- Жу Ючин. (1987). Хятадын орчин үеийн боловсролын тогтолцооны түүхэн материалууд" (2-р боть дээд дэвтэр). Шанхай: Хуадун Багшийн Их Сургуулийн хэвлэлийн хороо.
- Шү Фушяан. (2021). Чэн гүрний хожуу үеийн харчин баруун хошуу даахь шинэ боловсрол ба Монгол, Хятад үндэстэний харилцаа--“Монголын Төвийг сахих цэргийн сургууль, Төвийг эрхэмлэх сургуулийн хувьслын дүрэм”-ээр гол болгосон. Гирнийн багшийн их сургуулийн сэтгүүл (хүнлэг, нийгмийн шинжлэх ухааны хэвлэл) №1. Сипин.
- Мисако Ичиномия. (1909). Монгол бэлэг. Токио: Жицүгёо но Нихон компани (Jitsugyo no Nihon sha).
- Мисако Кавахара. (1969) Харчин вангийн хатан бид хоёр— Монгол үндэстэний зүрх сэтгэлд амилсан эмэгтэй багш. Токио: Фүё номын өргөө.
- Миса Манабе. (2006). Эзэн хатан Шокен ба Язгууртны охидын сургууль--байгуулах, шинэчлэхэд эзэн хатаны гүйцэтгэсэн үүргийн жишээн дээр. Ном, Бунханы хэлтсийн эмхэтгэл No58. Токио: Ордны Дотоод Яамны ном, бунханы хэлтс.

- Кенчу Такаяма, Бүрцэцэг. (2010). Эрт үеийн Өвөр Монголын Харачин баруун хошуу дахь Япон хэлний сургууль. Нагасаки Веслеян их сургуулийн орчин үеийн социологийн тэнхимийн эмхэтгэл. 8-р боть No 1. Исахаяа.
- Бао Жинхуа. (2013). Өвөр Монголын орчин үеийн охидын сургууль байгуулагдсан нь--Төвийг хүмүүжүүлэх охидын сургуулийн дүрэм, бодит байдалд үндэслэсэн. Азийн боловсрол No7. Коби.
- Боловсролын түүхийн эмхэтгэлийн холбоо. (1938). Мэйжийн үеэс хойшхи боловсролын тогтолцооны хөгжлийн түүх, 3-р боть . Токио: Рюгин компани.
- Хидео Сато. (2005). Боловсролын соёлын түүх (2) Сургуулийн соёл. Киото: Аун компани.
- Зоригт, Н. (2008). Манж чин улсын сүүлийн үеийн Өвөр Монголын Япон хэлний боловсрол--Өвөр Монголын Харчны Төвийг хүмүүжүүлэх охидын сургууль ба Кавахара Мисоко (Магистрын зэрэг хамгаалсан өгүүлэл). Токио: Межиро их сургууль.
- Шимода Утакогийн намтар. (1945). Токио: Талийгаач захирал Шимода багшийн намтар редакцийн хүрээлэн.
- Орчин үеийн Азийн боловсролын түүхийн судалгааны нийгэмлэг. (2002). Орчин үеийн Японы Азийн боловсролын ойлголт • материалын эмхтгэл, 12-р боть, Хятдын хэсэг (4). Токио: Рюкэй номын өргөө.
- Орчин үеийн Азийн боловсролын түүхийн судалгааны нийгэмлэг. (2002). Орчин үеийн Японы Азийн боловсролын ойлголт • материалын эмхтгэл, 29-р боть, Хятдын хэсэг (21). Токио: Рюкэй номын өргөө.
- Японы Үндэсний Архив Дижитал Архив. (1893). Хүсэлтийн дугаар: Анги 00663100. Сэдвийн дугаар: 029. Язгууртны охидын сургуулийн дүрэмд өөрчлөлт оруулах. Мэйжи 26 оны 8-р сарын 23. URI: <https://www.digital.archives.go.jp/item/1719301>
- Японы үндэсний архивын Азийн түүхийн материалын төвийн Дижитал архив. (1907). Лавлах код: B04011142500. Монголын Харчин вангийн хүсэлтээр Японы инженерийн хийсэн тариалан аж ахуй, уурхайн байцаалтын нэг мэдээлэл (Мэйжи 38 оны 2-р сараас Мэйжи 40 оны 11-р сар хүртэл). URI:<https://www.jacar.archives.go.jp/das/image/B04011142800>

Зохиогчдын мэдээлэл

Овог, нэр: NA ZHAORIGETU

 <https://orcid.org/0009-0002-1520-3567>


Байгууллагын нэр: Chifeng University

Хаяг: No. 1 Yingbin Road, Hongshan District,
Chifeng City, Inner Mongolia

Улс: China

e-mail: zhaori1223@163.com

Овог, нэр: Галиндэвийн Өлзийсайхан

 <https://orcid.org/0000-0003-4686-2469>

Байгууллагын нэр: МУБИС

Хаяг: Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг,
8 дугаар хороо, Бага тойруу-14, МУБИС-
ийн хичээлийн IX байр.

Улс: Монгол

e-mail: ulziisaikhan@msue.edu.mn